



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл  
2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Лхагва гараг*

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-4
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	5-12

---

<i>1.Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр</i>	5-7
<i>2.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	7-12

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
4 дүгээр сарын 29-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 32 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Э.Болормаа, Х.Жангабыл, Ц.Мөнхбат, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Л.Оюун-Эрдэнэ, Х.Тэмүүжин, Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Очирбат, Б.Тулга.

**Нэг.Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Одбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсийн дарга А.Энх-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, мөн хэлтсийн мэргэжилтэн М.Баярмаа, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Д.Болормаа, мөн газрын улсын ахлах бүртгэгч Ө.Өнөрлхам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Кадастрын хэлтсийн дарга Б.Батжавхлан, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Хууль зүйн хэлтсийн дарга Б.Баясалмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг нар байлцав.

Хэлэлцээрийн төслийг Батлан хамгаалахын сайд Д.Батлут танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар уг асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг 11 цаг 47 минутад хаалттай горимд шилжүүлэв.

*Хаалттай хуралдаан 1 цаг 32 минут үргэлжилж, 13 цаг 20 минутад нээлттэй горимд шилжив.*

**Хоёр.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Батлан хамгаалахын дэд сайд Д.Баасандамба, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч Б.Мөнх-Ирээдүй, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, мөн газрын Улсын нисэхийн хэлтсийн дарга П.Идэр, Төрийн захиргаа, удирдлагын газрын ахлах шинжээч, хуулийн зөвлөх Г.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Батлан хамгаалахын сайд Д.Батлут танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, П.Наранбаяр, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд Д.Батлут хариулж, тайлбар хийв.

**Г.Тэмүүлэн:** 1.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хамт өргөн мэдүүлсэн:**

2.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Нээлттэй хуралдаан 39 минут үргэлжилж, 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 44 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр,  
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 11 цаг 32 минут

### **АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Ирцийг та бүхэндээ бас танилцуулъя.

Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Батын Батбаатар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Лувсанн्याмын Гантөмөр гишүүн, Сүрэнжавын Лүндэг гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн Лутаагийн Энхнасан гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн нарын гишүүд хүрэлцэн ирснээр ингээд 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хурлаар хэлэлцэх 2 асуудал байгаа. 2 асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрх нь Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл байгаад байгаа. Засгийн газар 4 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн зөвшилцөх асуудал байна.

2 дахь асуудал нь Улсын нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл байгаа. Хамт өргөн мэдүүлсэн хуулиудын хамтаар Засгийн газар 4 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн байна аа. Ингээд хэлэлцэх эсэх асуудалтай ийм 2 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байгаа юу? алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн хүрэлцэн ирлээ. Ирц 55.2 болсон байна. 29-16 гишүүн.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Ингээд уг танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Дамбын Батлут сайд танилцуулна аа. Таныг микрофонд урьж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулахыг хүсье. Батлут сайд танилцуулмаар байна.

**Д.Батлут:** Эрхэм гишүүд ээ,

Улаанбаатар хотноо 2016 онд байгуулсан Монгол Улс, ОХУ-ын хооронд Стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт зааснаар талууд 2 улсын үл хөдлөх хөрөнгийн асуудлыг үе шаттайгаар олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхээр тохиролцсон.

Мөн 2019 онд байгуулсан Найрсаг харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс ОХУ-ын хоорондын гэрээнд талууд өөрийн нутаг дэвсгэрт байрлах хөрөнгийн хувьд бие биеийн хууль ёсны эрх ашиг болон ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч хангана гэж заасан байдаг. Үе шаттайгаар шийдвэрлэх зорилтын хүрээнд 1 дүгээр үе шат буюу БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны протокол болон БНМАУ-ын нутаг дэвсгэрт газар олгох барилга барих нөхцөлийн тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газрын хоорондын 1979 оны хэлэлцээрт нууц солилцох замаар 2019 онд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж зарим үл хөдлөх хөрөнгийн эрхийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн байсан.

Энэ ажлын 2 дугаар үе шатын хүрээнд Монголын талаас ТӨБЗГ-ын даргаар ахлуулсан Монгол, Оросын хамтарсан ажлын хэсэг Улаанбаатар, Чойбалсан, Эрдэнэт хотод байрлах 8 газар, 93 үл хөдлөх хөрөнгийн объектыг ЗСБНХУ-ын нэр дээрээс ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгүүлэх шаардлагатай гэж үзсэн. Энэ хүрээнд талууд эдгээр үл хөдлөх хөрөнгийг ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийг тусгасан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг хавсралтуудын хамт боловсруулан эцэслээд байна аа.

Мөн өнгөрөгч оны 12 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газрын хоорондын комиссын 27 дугаар хуралдааны протоколд талууд хамтарсан ажлын хэсгийн хүрээнд боловсруулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн үндсэн дээр Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах ОХУ-ын 2 дугаар ээлжийн үл хөдлөх эд хөрөнгийн объектуудын эрхийг шинэчлэн бүртгэх арга хэмжээг авахаар тохиролцсон. Тус Засгийн газрын хоорондын хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулиар соёрхон батлах олон улсын гэрээ тул хэлэлцээрт гарын үсэг зурахад шаардлагатай холбогдох дотоодын журмыг хангаж өгөхийг Монголын талын ажлын хэсгээс буюу ТӨБЗГ, ГХЯ-нд хүсэлт болгосны дагуу тус яамнаас Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаан болон Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлж байна аа.

Иймд асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Батлут сайдад баярлалаа. Энэхүү Засгийн газар хоорондын хэлэлцээртэй холбоотойгоор Засгийн газраас орж ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя.

ТӨБЗГ-ын дарга Цэнгэл, Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга Энхболд, Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын даргын үүргийг гүйцэтгэгч Одбаяр

гэсэн байна. ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Зөвшөөрөл бүртгэлийн хэлтсийн дарга Энх-Эрдэнэ, ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл ашиглалт хэлтсийн дарга Нарангэрэл, ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл ашиглалт хэлтсийн дарга Баярмаа, ГХЯ-ны Гэрээ эрх зүйн газрын дэд захирал Бат-Өлзий, дэд сайд байна уу тийм байна. ГХЯ-ны дэд сайд Амартүвшин байна. Амартүвшин сайд ирсэн байна. УБЕГ-ын Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын дарга Болормаа, Улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Өнөрлхам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Кадастрын хэлтсийн дарга Баянтүмэн, НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга Үнэнбат дарга байхгүй байна уу? За Мөнхбаатар дарга байна уу нийслэлээс? Алга байна, байна уу. Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга Мөнхбаатар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны кадастрын хэлтсийн дарга Батжавхлан, Нийслэлийн өмчийн харилцааны газрын Хууль зүйн хэлтсийн дарга Баясалмаа гэсэн ийм бүрэлдэхүүнтэй оролцож байгаа юм байна аа.

Анар гишүүн горимын санал гаргая гэсэн байна. Анар гишүүний микрофоныг өгье.

**Ч.Анар:** Өдрийн мэнд эрхэм гишүүд ээ. Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтойгоор хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх саналтай байна.

**Г.Тэмүүлэн:** Анар гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад горимын санал гаргаж байна. Горимын саналаас гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдье. Гишүүд төхөөрөмжөө идэвхжүүлээрэй. Лүндэг гишүүн төхөөрөмжөө идэвхжүүлээрэй. Ороогүй байна орчихлоо. Санал хураалтыг явуулъя.

Анар гишүүний гаргасан хаалттай дэгээр хэлэлцэх горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Горимын санал 52.9 хувиар дэмжигдлээ. 9 гишүүн дэмжсэн байна. Ингээд хаалттай горимд бэлтгэе.

**Г.Тэмүүлэн:** Хэлэлцүүлгийг явуулъя аа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой албан тушаалтнуудыг оруулаарай.

***Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Батлан хамгаалахын сайд Дамбын Батлут сайд танилцуулна аа. Батлут сайдыг микрофон дээр урьж байна.

**Д.Батлут:** Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн 74-т Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж заасныг хэрэгжүүлэх хүрээнд Улсын нисэхийн тухай

хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-д заасны дагуу хуулийн төслийн бүрдүүлбэрийг ханган Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Улсын нисэхийн тухай хууль нь 2003 онд анх батлагдаж, улсын агаарын хөлгөөр нисдэг нислэг үйлдэх улсын нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж ирсэн бөгөөд цаг үеийн шаардлагаар 6 удаа нэмэлт өөрчлөлт орж байсан юм. Энэ удаагийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтүүд оруулаад байна аа.

Тухайлбал улсын нисэхийн асуудлыг удирдан чиглүүлэх Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын чиг үүргүүдийг нарийвчлан тодорхойлсон хуулийн үйлчлэлд хамаарах Зэвсэгт хүчин, ХХЕГ, ОБЕГ зэрэг байгууллагууд шинээр агаарын хөлөгтэй болж байгаатай холбогдуулан тэдгээрийн нэгдсэн бодлого удирдлагаар хангахтай холбогдсон харилцааны асуудлыг, улсын агаарын хөлгийг бүртгэх нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, гадаадын иргэн гэрээгээр үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг, улсын нисэхийн багц дүрмээр зохицуулах харилцааг нарийвчлан зааж, улсын нисэхийн аюулгүй байдал, нислэгийн ажиллагааны хяналт, зохицуулалтын талаар харилцааг боловсронгуй болгох зэрэг эрх зүйн зохицуулалтуудыг нэмж тусгасан нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиас онцлог болсон гэж үзэж байна аа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагууд болон олон нийтийн оролцоог хангах зорилгоор БХЯ-ны цахим хуудсанд байршуулж, хуулийн төслийн хэлэлцүүлгийг хийж ТББ-аас санал авахад бүгд дэмжсэн бөгөөд хуулийн төсөлд ирүүлсэн саналыг хүлээн авч тусгаснаар хуулийн төсөл нь 9 бүлэг, 25 зүйл, 68 хэсэг, 91 заалттайгаар эцэслэн боловсрогдсон болно оо.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт зардал шаардагдахгүй бөгөөд улсын нисэхийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, ААН төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын хүлээх үүрэг хариуцлага, хяналт, зохицуулалт тодорхой болж, нислэгийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин сайжирч, түүнийг дагалдаж хуулийг хэрэгжүүлэх бусад эрх зүйн баримт бичгүүд боловсронгуй болгох ач холбогдолтой юмаа.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Батлут сайдад баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүдийн нэрсийг авчихъя. Наранбаяр гишүүнээр тасалъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Батлан хамгаалахын дэд сайд Баасандамба. Анар гишүүнийг нэмээд оруулъя асуулт дээр. ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Ганбямба дарга ирсэн байна. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч бригадын генерал Мөнх-Ирээдүй хүрэлцэн ирсэн байна. Тус яамны ТНБД хошууч генерал Ганхуяг дарга хүрэлцэн ирсэн байна. Стратегийн бодлого,

төлөвлөлтийн газрын дарга хурандаа Гансүх хүрэлцэн иржээ. Дэд сайд Баасандамба даргыг хэлсэн байгаа. Батлан хамгаалахын дэд сайд Баасандамба, тус яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Улсын нисэхийн хэлтсийн дарга хурандаа Идэр, ТЗУГ-ын ахлах шинжээч хуулийн зөвлөх Энхболд гэсэн бүрэлдэхүүнтэй байна аа.

Анар гишүүн асуулт асууна.

**Ч.Анар:** Өдрийн мэнд. Би ганцхан асуулт асууя. Энэ дроны зохицуулалтыг дрон дээр бол автомат удирдлагатай нисгэгчгүй нисэх хэрэгслээр хуульд орж ирсэн байна. Одоо орчин үед нөгөө байлдааны нөхцөл байдлаас жишгээр нь дроныг их олон ангилаад зарим дронууд бол нөгөө галт зэвсгийн төрөлд ордог болчихоод байгаа сум, сумны төрөлд ордог болчихсон байгаа. Тэгэхээр энэ хууль дээрээс үүдээд энэ дараад нь бүх дрон нь нэг ангилалд тээврийн нисэх хэрэгсэлд орчих вий дээ. Тэр өөр зохицуулалтуудыг яаж дараад нь хийж өгөх вэ? Аль хууль дээр оруулж ирэх вэ? Одоо сурон дроныг бол ерөөсөө сумны ангилалд дэлхий нийтээрээ оруулдаг болчихоод байгаа шүү дээ.

Тэгэхээр тэр нь энэ дараа нь та нар энэ батлан хамгаалахын чиглэлийн үйл ажиллагаан дээрээ энэ асуудал үүсэх үү, үгүй юү? Тэрийг бодож үзсэн болов уу?

**Г.Тэмүүлэн:** Анар гишүүний асуултад хариулъя. Батлут сайд.

**Д.Батлут:** Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая аа. Өнөөдрийн энэ улсын нисэхийн тухай хууль 2003 онд анх батлагдаж байсан. Түүнээс хойш 6 удаа өөрчлөлт шинэчилж найруулсан байгаа. Түүнээс одоо 5 удаагийнх нь үндсэндээ хууль дагалдаж, нэг удаа зарчмын хувьд шинэчилсэн найруулгыг хийж байсан. Өнөөдөр тухайн цаг үеийнхээ нөхцөл байдалтай уялдуулан шинэчилсэн найруулгаар өргөн барьж мэдүүлээд явж байна аа.

Дронтой холбоотой зохицуулалтуудыг бас энэ хуулийн төсөлд төслөөс урган гарч байгаа журамд тодорхой зохицуулалтууд хийж өгч байгаа. Тэгэхдээ тэр бол зөвхөн цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгсэл ашиглах, нислэг дадлагажуулалтын зохицуулалт ашиглах зэргийг дүрмийн зохицуулалтаар багц дүрэмд шингээж өгсөн байгаа. Энэ хуулийн одоо хуучин хэрэгжиж байгаа хуулийн хүрээнд бол нэг 7 багц журам бий. Энэ хууль шинэчлэн найруулагдаж гарснаараа 9 багц журамтай болж байгаа. Тэр хүрээнд энэ цэргийн зориулалттай нисдэг нисгэгчгүй нисэх төхөөрөмж дронтой холбоотой зохицуулалтуудыг нарийн тусгаж зохицуулж өгч байгаа. Ер нь бол Цахим хөгжлийн яамнаас энэ дроны хэрэглээтэй холбоотой хуулийн төслийг өргөн барихаар ажлын хэсэг ажиллаж байгаа юм. Тэр одоо ердийн хэрэглээтэй холбоотой асуудлууд тэр хуулийн төслөөр зохицуулагдаж орж ирнэ ээ гэдгийг хэлье.

**Г.Тэмүүлэн:** Наранбаяр гишүүн асуулт асууя.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Энэ яах вэ энэ нөгөө иргэний нисэхээс ялгаж улсын нисэх гэж ингэж оруулж ирдэг юм байна гэж би ойлгосон. Зүгээр энэ гээд юуг нь бол нэр томъёоны тайлбарыг харахаар 4.1.13 дээр улсын нисэх гэж улсын агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхтэй холбогдсон цогцолбор ойлголтыг гээд ингээд яачихсан байгаа. Энийг арай жоохон дэлгэрэнгүй, илүү ойлгомжтойгоор, өөрөөр хэлбэл иргэний нисэхээс ялгаатай энэ батлан хамгаалахын чиглэлийн гэдэг

энэ байдлаар нь томьёолж болоогүй юм уу л гэж асуух гэсэн юм. Бусад зүйлүүд бол энэ дандаа мэргэжлийн зүйлүүд байна лээ. Зүгээр энийг тэгж маш сайн ойлголтыг нь зааглаж өгч болоогүй юм уу л гэж асуух гэсэн юм. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Батлут сайд.

**Д.Батлут:** Улсын нисэхийн тухай хууль гэж 2003 онд батлагдсан гэж би түрүүн хариулсан. Иргэний нисэхийн тухай хуулийн асуудал бол олон улсын хууль болоод иргэний нисэхийн хуулиар зохицуулагдаад явж байгаа. Тэр нь өөрөө яг тийм томьёоллоор явж байгаа. Энэ улсын нисэхийн тухай хууль гэхлээр манай зэвсэгт хүчинтэй холбоотой онцгой байдал, хилийн цэрэгтэй холбоотой цаашлаад одоо эрүүл мэндийн салбар ч гэдэг юм уу өргөжин тэлэх ийм салбартай холбоотой зохицуулалтуудыг энэхүү хууль эрх зүйн зохицуулалтуудаар зохицуулж өгч байгаа асуудал юмаа.

Тэгэхээр ялгаа зааг нь бол тусдаа. Нэг нь Иргэний нисэхийн тухай хуулиар, нөгөөдөх нь Улсын нисэхийн тухай хуулиар ингээд зохицуулж явж байгаа гэж ойлгож болно оо. Тэгэхдээ таны саналыг хүлээж аваад тэр тайлбар дээр нь тодорхой бас нэг онцгойлох зүйлүүдийг бид нар анхааръя гэж бодож байна аа. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Наранбаяр гишүүн нэмж тодруулъя.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Тэгэхээр яг бас болж байна л даа тэгээд саналыг хүлээж байгаад баярлалаа. Тэгэхээрээ улсын нисэх гэж иргэний нисэхээс бусад гэсэн тийм утгаар үгийг нь оруулаад тиймээ ингээд л оруулчих юм бол энэ хооронд ерөөсөө хоорондоо нөгөө холилдоод байхгүй сайхан ингээд зааглагдаад ирэх болов уу гэж. Яагаад ингэхээр нөгөө нэр томьёо хуулийн энэ зааг ялгаа чинь маш чухал байдаг. Ингээд хоорондоо хольчихоор сүүлдээ эрх мэдлийн тэгээд эрх үүргийн, хариуцлагын эд нарыг нь холилдоон үүсгээд ойлгомжгүй байдлыг үүсгэдэг учраас та бүхэн маань иргэний нисэхээс бусад зорилгоор гэдэг юм уу ийм байдлаар та бүхэн маань энийг оруулаад өгөхийг хүсэж байна аа. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Батлут сайд.

**Д.Батлут:** Энэ хуулийг өргөн барьснаараа Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх ямар байх юм. Засгийн газрын төрийн батлан хамгаалах төрийн захиргааны төв байгууллага цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага ямар үүрэгтэй байх юм, улсын агаарын хууль эзэмшигч байгууллагуудын эрх үүрэг гээд бүгдийг нь ингээд шинэчлэн тодорхойлоод өгчихөж байгаа юм. Тэгэхээр таны хэлж байгаагаар одоо ингээд иргэний нисэх гэхэд тусдаа, улсын нисэх болон бусад гэж орчихлоор нөгөө бидний тодорхойлоод байгаа Зэвсэгт хүчний болоод онцгой, шүүхийн шийдвэрийн юу хил хамгаалахтай холбоотой асуудлаас бусад нөгөө хувийн хэвشلүүд хамрагдаад явчих тийм нөхцөл байдлууд үүснэ. Тийм учраас бид нар яг тодорхойлоод энэ 3 байгууллага цаашлаад төрийн чиглэлээр ЭМЯ магадгүй энэ өргөн дэлгэр газар нутагтай янз бүрийн өвчин зовлон осол гэмтэл гарангуут яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор нисдэг тэрэг...

**Г.Тэмүүлэн:** Нэмж хариулъя Батлут сайд.

**Д.Батлут:** Тийм одоо нөхцөл байдал үүссэн цагт энэ эрх зүйн зохицуулалтуудаар харилцаагаа зохицуулаад явах боломжтой болно оо л гэж ойлгож болно оо.

**Г.Тэмүүлэн:** За баярлалаа. Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

**С.Эрдэнэболд:** Хуулийн үзэл баримтлалыг дэмжиж байгаа. Тэгэхдээ нэг тодруулах зүйл байна. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг ер нь ингээд энэ жил хавар юм уу, намрын чуулганы аль нэгд нь орж ирэх юм байна гэсэн ойлголттой байгаад байгаа. 2010 онд баталсан Аюулгүй байдлын үзэл баримтлал болохоороо үндсэн 6 бүлэг явж байгаа. Зүгээр мэдээлэл бол одоо ямар ойлголттой байна гэхээр тэр Анар гишүүн бид хэд бас санал солилцсон. Одоо энэ хэрэгжиж байгаа үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал маань нэг хөндлөнгийн судлаачдаар харахаар нэг 70 хувийн хэрэгжилттэй явж байна гээд. Яагаад хэрэгжихгүй 30 хувь нь гэхээр нөгөө хугацаа заасан зүйл их байгаад байгаа. Жишээлбэл одоо 2020 он гэхэд гэж байгаа. Одоо 6 жилийн өмнө гэхэд эрчим хүчний бие даасан хараат бус байдлаа 100 хувь бүрэн хангадаг болно, шатахууны хувьд ч гэсэн бүрэн хангадаг болно гээд баахан зорилгууд тавьчихсан. Тэгэхээр одоо бол энэ боловсруулагдаж байгаа төсөл нь болох юм бол 2 хуваагдаад нэг нь яг ингээд тунхаг зорилгын шинж чанартай зүйлс нь, яг хөдөлшгүй зүйлс нь нэг хэсэг. Нөгөө талдаа болохлоор яг энэ зорилттой хугацаатай зүйлүүдийг нь арай нэг өөр экшин план маягаар гаргая гээд явж байгаа юм байна гэж ойлгосон. Тийм ойлголттой байгаад байгаа юм.

Тэгээд ер нь бол бид нар ингээд юм болгон дээр л нэг баталсан зарчим богино, дунд, урт хугацааны бодлогодоо ер нь нийцэх ёстой. Тэгэхээр энэ одоо яг энэ гарч байгаа хуулийн төслийн танилцуулга маань яг энэ шинэ боловсруулагдаж байгаа үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа ер нь зохих мэргэжлийн албан харилцааны журмаар нийцэгдэж байгаа тал дээр та нар ажилласан уу гэдэг нь бол нөгөө аюулгүй байдлын үзэл баримтлал маань ойрын 1, 2 чуулганы хугацаанд ороод ирдэг. Тэр маань энэ хуулийн үзэл баримтлалтайгаа уялдаж байгаа юу гэсэн нэг асуулт байна. Зүгээр ажлын хэсэгт хэлэхэд жишээлбэл 4.1.16 дээр жишээлбэл том үсгээр эхэлсэн, бусдад нь болохоороо жижиг үсгээр эхэлсэн ч гэдэг юм уу ийм нэг ийм редакц техникийн ажлууд байна шүү. Тэрэн дээр бас анхаараарай гэж хэлмээр байна.

**Г.Тэмүүлэн:** Батлут сайд Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

**Д.Батлут:** Эрдэнэболд гишүүндээ баярлалаа. Манайхан тэр редакцын шинж чанартай асуудлууд дээр ажлын хэсгийнхэн анхаараад ажиллачихна аа гэдгээ хэлье. ҮАБЗ-ийн үзэл баримтлал болоод бусад хууль эрх зүйн хүрээнд одоо нийцэж байгаа юу гэдэг асуудлыг та асууж байна. Тэгэхээр бид бүхэн бол үүнтэй бүх зүйл дээр нийцүүлэх одоо цаг үед болоод ирээдүй цаг үед бас ямар байх нөхцөл байдал байгаа вэ гэдэг дээр тодорхой хэмжээний хэлэлцүүлэг, судалгаа шинжилгээний ажлууд давхар хийж хэрэгжүүлсний үндсэн дээр энэ хуулийн төслийг боловсруулан өргөн барьсан байгаа. Тийм учраас ямар нэгэн тийм зөрчилдөх агуулга шинж бол байхгүй ээ гэж ойлгож болно оо.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Нэрсийг авъя. Алга байна.

Санал хураалтыг явуулна аа. Санал хураалт явуулах горимд шилжье. Бэлтгэл ажлыг хангая. Бэлэн байдалд 8 гишүүн байна. Эрдэнэбүрэн гишүүнийх ороогүй байна уу орсон 9 байна. Санал хураалтыг явуулъя. Энхтүвшин гишүүн бэлтгэлээ хангаарай.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан энэ хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Түр хүлээж байгаарай.

55.6 хувиар дэмжигдлээ.

3 санал хураалттай байгаа. Хоёрдугаарх нь дагалдах хууль буюу Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах. Энэ хүчингүй болсон юм байна шүү дээ тиймээ. Тийм байна тийм байна ойлголоо.

Саяын санал хураалт дэмжигдсэнтэй холбогдуулаад Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

55.6 хувиар дэмжигдлээ. Баярлалаа.

3 дахь нь. Дагалдах хууль буюу Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа.

55.6 хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсэг гишүүдэд баярлалаа. Илтгэгч гишүүнийг чуулганд томилохоор байгаа. За тэлье. Хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаарх байнгын хорооны хуралдаан, Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүнээр Анар гишүүнийг томилж байна аа.

Ингээд хэлэлцэх асуудал дууссан байна. Гишүүддээ идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

13.43 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА